

САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 301

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

- 1."Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.
- 3.Тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан арга зүйгээр хангаж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/-д даалгасугай.

САЙД Ч.ХҮРЭЛБААТАР